

**ЗАМ, ТЭЭВРИЙН ХӨГЖЛИЙН ЯАМНЫ ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ  
НИЙТИЙН МЭДЭЭЛЛИЙН ИЛ ТОД, НЭЭЛТТЭЙ БАЙДЛЫН  
ХЭРЭГЖИЛТЭД 2023 ОНЫ ЖИЛИЙН ЭЦСИЙН БАЙДЛААР  
ХЯНАЛТ-ШИНЖИЛГЭЭ, ҮНЭЛГЭЭ  
ХИЙСЭН АЖЛЫН ТАЙЛАН**

2024.01.17

Улаанбаатар хот

**Нэг. Хяналт-шинжилгээ, үнэлгээний зорилго:**

Нийтийн мэдээллийн ил тод байдлын тухай хууль 2022 оны 5 дугаар сарын 1-ний өдрөөс хэрэгжиж эхэлсэнтэй холбогдуулан уг хуулиар заасан үндэслэл, журмын дагуу иргэний мэдээлэл хайх, хүлээн авах эрхийг хангах, нийтийн мэдээллийн дэд бүтцийн эрх зүйн үндсийг тогтоох, төрийн үйл ажиллагааг цахим хэлбэрээр явуулах, нээлттэй, ил тод, шуурхай байлгах, төрийн үйл ажиллагаанд олон нийтийн хяналтыг бий болгоход оршино.

Засгийн газрын 2020 оны 206 дугаар тогтоолоор баталсан “Бодлогын баримт бичгийн хэрэгжилт, захиргааны байгууллагын үйл ажиллагаанд хяналт-шинжилгээ, үнэлгээ, хийх нийтлэг журам”-ын 9 дүгээр хавсралтад заасан мэдээллийн ил тод, нээлттэй байдлын шалгуур үзүүлэлтүүдийн дагуу Зам, тээврийн хөгжлийн яамны үйл ажиллагаанд мэдээллийн ил тод байдлын явцыг идэвхжүүлэх, газар, хэлтэс, албан хаагчдын хариуцлагыг дээшлүүлэхэд дэмжлэг үзүүлэх зорилготой энэхүү хяналт-шинжилгээ, үнэлгээний ажлыг хийж гүйцэтгэлээ.

**Хоёр. Танилцуулга:**

Мэдээллийн ил тод байдал ба мэдээлэл авах эрхийн тухай хуулийг хэрэгжүүлэх, төрийн үйл ажиллагааг нээлттэй, ил тод, хүнд сурталгүй, авилгаас ангид байлгах, иргэдэд үйлчлэх үйлчилгээг ил тод хөнгөн шуурхай болгох, хангах талаар Зам, тээврийн хөгжлийн яамнаас хийж буй ажлын явцад Засгийн газрын 2020 оны 206 дугаар тогтоолоор баталсан “Бодлогын баримт бичгийн хэрэгжилт, захиргааны байгууллагын үйл ажиллагаанд хяналт-шинжилгээ, үнэлгээ, хийх нийтлэг журам”-ын 9 дүгээр хавсралтад заасан ил тод байдлын шалгуур үзүүлэлтүүдийн дагуу үнэллээ.

Нийтийн мэдээллийн ил тод байдлын тухай хуулийн шалгуур үзүүлэлтийн 5 хэсгийн 46 арга хэмжээний хэрэгжилт 2023 оны жилийн эцсийн байдлаар **98.5** хувь байна. Шалгуур үзүүлэлт тус бүрийн үнэлгээг хүснэгтээр харуулбал:

/Хүснэгт 1/

Хэсэг	Нийт Арга хэмжээ	Үнэлгээ /хувиар/					Хугацаа болоогүй	Чиг үүрэгт хамаарахгүй	ХШҮ
		100	70	30	0				
1	10	8	1	-	-	1	-	96.6	
2	6	5	-	-	-	1	-	100.0	
3	15	15	-	-	-	-	-	100.0	
4	2	2	-	-	-	-	-	100.0	
5	13	7	1	-	-	3	2	96.2	
<b>Нийт</b>	<b>46</b>	<b>37</b>	<b>2</b>	<b>-</b>	<b>-</b>	<b>5</b>	<b>2</b>	<b>98.5</b>	

Харьяа байгууллагуудын нийтийн мэдээллийн ил тод, нээлттэй байдлын шалгуур үзүүлэлтийг улирал бүр хяналтад авч, хяналт-шинжилгээ, үнэлгээ хийж байна. 2023 оны жилийн эцсийн байдлаар харьяа байгууллагын нэгдсэн дүнг хүснэгтээр үзүүлбэл:

/Хүснэгт 2/

№	Харьяа байгууллага нэр	Нийт арга хэмжээ	Үнэлгээ /хувиар/				Чиг үүрэгт хамаарахгүй	ХШҮ
			100	70	30	0		
1	АТҮТ	46	27	3	2	4	10	82.5
2	ЗТХТ	46	22	2	2	7	13	72.7
3	ИНЕГ	46	32	3	-	5	6	85.2
4	НТОЗШША	46	9		2	1	34	80.0
5	МИАТ	46	28	1	2	2	13	88.8
6	ХХНОБ	46	13	4			29	92.9
7	ГТХЗНТ	46	25	5	1	-	15	92.9
8	ДЗ	46	23	1		4	18	84.6
9	МТЗ	46	34	4		2	6	92.0
10	УБТЗ	46	15	1	2	6	22	67.9
11	ТТЗ	46	30	3	3	3	7	84.6
<b>Нийт</b>		<b>506</b>	<b>258</b>	<b>27</b>	<b>14</b>	<b>34</b>	<b>173</b>	<b>94.0</b>

*Засгийн газрын 2020 оны 206 дүгээр тогтоолоор баталсан “Бодлогын баримт бичгийн хэрэгжилт болон захиргааны байгууллагын үйл ажиллагаанд хяналт-шинжилгээ, үнэлгээ хийх нийтлэг журам”-д заасны дагуу Мэдээллийн ил тод байдлын шалгуур үзүүлэлтийн хэрэгжилтийг 2023 оны жилийн эцсийн байдлаар ЗГХХГ-т цахимаар тайлагнасан.*

**ЗАМ, ТЭЭВРИЙН ХӨГЖЛИЙН ЯАМ.**